



БАЯНХОНГОР АЙМАГ  
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 23 өдөр

Дугаар А/64

Хөхбүрд

Уранхайрхан 2 дугаар багийн камержуулалтын  
ажлыг хүлээлцэх комисс томилох тухай

Монгол Улсын Засаг Захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ны өдрийн 86 тоот тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сан”-гийн үйл ажиллагааны журмын 4.4 заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр гүйцэтгэсэн Уранхайрхан 2 дугаар багийн камержуулалтын ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын ахлагч:С.Энх-Амгалан (Уранхайрхан 2 дугаар багийн Засаг дарга)

Гишүүд: Д.Эрдэнэбулган (Санхүүгийн албаны дарга)

Л.Гүндцамба (Хөдөө аж ахуйн тасгийн дарга)

Э.Мөнх-Эрдэнэ (Сан хариуцсан нягтлан бодогч)

Л.Должинсүрэн (Уранхайрхан 2 дугаар багийн иргэн)

2.Уранхайрхан 2 дугаар багийн камержуулалтын ажлыг гэрээний дагуу нэг бүрчлэн бүртгэж, тулгаж, акт, хурлын тэмдэглэл үйлдэн хүлээж авахыг ажлын хэсэгт даалгасугай.

3.Ажлыг хүлээн авсан акт, ажлын хэсгийн хурлын тэмдэглэл үйлдэн, Санхүүгийн албанд хүлээлгэн өгөхийг ажлын хэсгийн ахлагч (С.Энх-Амгалан)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Г.ОРХОНТУУЛ

642301133